



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 30 өдөр

Дугаар А/153

Хархорин сум

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ний өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын нутаг дэвсгэрт 2024 оны 07 дугаар сарын 18-ны өдөр хүчтэй аадар бороо, салхины аюултай үзэгдлийн улмаас үерээс хамгаалах далан сэтэрч, гүүр нурсан тул эвдрэл гэмтлийг сэргээн засварлах, үүссэн гуу жалгыг тэгшлэх, үерт урссан малын сэг зэм устгах, үер өртсөн айл өрхүүдэд ариутгал халдваргүйтгэл хийх зардалд зориулж 8,774,450 (найман сая долоон зуун дөчин дөрвөн мянга дөрвөн зуун тавь) төгрөгийн зардлыг хавсралтаар баталсугай.

2.Уг зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Лхагвадулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Г.ОДГЭРЭЛ

401100305

Хархорин сумын Засаг даргын 2024 оны
1-дугаар сарын 10-ны өдрийн
1/13 дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦООНЫ ЗАДАРГАА

Д/д	ҮЗҮҮЛЭЛТ	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Шатахуун (ДТ)	л	1595	3540	5,646,300
2	Шатахуун (ДТ)	л	55	2530	139,150
3	Хөдөлмөр хамгаалал	ш	1	162,000	162,000
4	Хоол	ш	1	235,000	235,000
5	Ковш хөлс	ш	1	1,300,000	1,300,000
6	Хово хөлс	ш	2	646,000	1,292,000
	Нийт дүн				8,774,450

--oOo--